

Балансын болон санхүү эдийн засгийн шинжилгээний хөгжилд МУИС-ийн оролцоо

The Contribution of NUM to the Development of the Balance Sheet Analysis and Financial and Economic Analysis in Mongolia

Б. Сайнжаргал¹, Л. Наранчимэг²

Хураангуй

Манай улсад нягтлан бодох бүртгэл тайлагнал, хяналт шалгалтын үндэсний систем болон балансын шинжилгээний үүсэл хөгжил төлөвшлийн асуудлыг хөндсөн. Баланс судлалаас эхлээд санхүү эдийн засгийн шинжилгээний онол арга зүйг нутагшуулан хөгжүүлэхэд МУИС-ийн нягтлан бодох бүртгэлийн тэнхим, багш нарын гүйцэтгэсэн үүрэг, оролцоог “нягтлан бодохын мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн түүх”, “баланс судлал, шинжилгээний хичээлийг зааж ирсэн түүх”, “суралцах материалын хангамж, шинэчлэл, мэргэжлийн судалгаа, боловсруулалтын ажил” зэрэг чиглэлүүдээр тодорхойлон бичлээ.

Түлхүүр үгс: баланс судлал, балансын шинжилгээ, аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ, эдийн засгийн шинжилгээний онол, аж ахуйн нэгж байгууллагын санхүү эдийн засгийн шинжилгээ, санхүү эдийн засгийн шинжилгээ

Abstract

This article addresses to the national system of accounting, reporting and accounting controls and, historical development for balance analysis in our country. Professors including lecturers engaged periodically in Accounting Department at the National University of Mongolia for developing a theory for financial economics from balance study in our country and financial analysis become played an important role. It applies to the role of them based on “history prepared accountant”, “history taught course named as “balance study, analysis”, “delivery and update for training materials”, and, “professional research and development”.

Keywords: balance study, analysis of balance sheet, entity operational analysis, the theory of economic analysis, financial and economic analysis of entity, finance and economic analysis

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн зөвлөх профессор, доктор
E-mail: sainjargal.b@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн дэд профессор, доктор
E-mail: naranchimeg_l@num.edu.mn

1. Нягтлан бодохын мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн түүх

Нягтлан бодох бүртгэл нь Эдийн засгийн болоод бизнесийн удирдлагын системд нэн эртний түүхтэй, мэдээлэл боловсруулалтын салбар ухаан гэж болно. Манай улсад Бүртгэл, тайлагнал, хяналт шалгалтын үндэсний системийг үүсгэн хөгжүүлэх, мэргэжилтэн бэлтгэх эхлэл 1921 оны ардын хувьсгалын дараахнаас хэрэгжиж эхэлсэн түүхтэй. Тухайлбал, гаалийн болон хоршооны түр курсээр бичиг үсэгтэй хүмүүсийг нягтлан бодогчоор сурган бэлтгэх, 1924 оны 6-р сард засгийн газрын шийдвэрээр Сангийн яамны дэргэд гаалийн нягтлан бодохын түр сургуулийг 2 багш, 40 сурагчтайгаар байгуулж Монгол хэл бичиг, сампингийн 4 аргын тоо, гаалийн дүрэм, дүн бүртгэл хөтлөх, мэдээ тайлан гаргах арга журмыг заах болсон нь мэргэжлийн сургалтын системийн эхлэл болжээ. 1926 онд Гаалийн түр сургуулийг Нягтлан бодохын түр сургууль болгон өргөтгөж, 6 сарын хугацаатай хичээллэхээр хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан Монгол бичиг, тоо бодлого, нягтлан бодох бүртгэл, хэмжилийн ухаан, банкны бүртгэл тооцоо, улс төр зэрэг хичээлийг заахаар болгожээ. Нягтлан бодохын энэхүү түр сургуулиар 200 гаруй мэргэжилтэн бэлтгэсэн бөгөөд 1929-1930 оны хичээлийн жилээс суралцах хугацааг 2 жил болгон суралцагчдын тоо, заах хичээлийг нэмэгдүүлэн, хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг Сангийн яамнаас батлан мөрдүүлж байхаар болгожээ.

1930-аад оноос Аж үйлдвэрийн комбинат, Төв цахилгаан станц, Төмрийн болон модон завод зэрэг үндэсний аж үйлдвэр, тээвэр холбооны салбарууд үүсэн, Сангийн аж ахуй, Өвс хадах морин станцууд

байгуулагдсанаар бүртгэл хөтөлж, тайлагнах нэгжийн тоо эрс нэмэгдэж, мэргэжлийн нягтлан бодохууд хүрэлцэхгүй болсны улмаас Сайд нарын зөвлөл (СнЗ)-ийн тогтоолоор 1935 оны 8-р сард Нягтлан бодохын сургуулийг өргөтгөн Санхүүгийн техникум байгуулах шийдвэр гаргаж, Нам улсын сургуулийн бүрэлдэхүүнд хичээллэж байсан худалдааны нягтлан бодогч, бараа түүхий эдийн ангиудыг энэ сургууль (техникум)-д татан нэгтгэж, ерөнхий эрдмийн болон нийгмийн ухааны хичээлүүдээс гадна нягтлан бодох бүртгэлийн үндэс, салбаруудын нягтлан бодох бүртгэл, улсын орлого зарлага болон төсөвт газрууд, банкны бүртгэл, Балансын шинжилгээ, төлөвлөгөө, тоо бүртгэл (статистик) зэрэг мэргэжлийн хичээлүүдийг заах болсоноор сургалтын агуулга, хэмжээний хувьд тусгай мэргэжлийн сургуулийн жишигт хүрч ирсэн том ахиц байлаа. Гаалийн болон Нягтлан бодохын сургуулиар 1924-1935 онд 420 орчим, техникумаар 1935-1946 онд 500 шахам мэргэжилтэн бэлтгэж, 1941 онд техникум суралцагчид төгсөгчдөөс анхлан 7 хүнийг (цаашид жил дараалан) Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-ад явуулан суралцуулж дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэдэг болсон.

МУИС-ийн Эдийн засгийн салбарыг 1947 онд нээсэн, 1953 онд СнЗ-ийн 182-р тогтоол (Улс ардын аж ахуй (УААА)-н бүх салаа мөчирт Нягтлан бодох бүртгэл, тайлан ба хяналт, санхүүгийн сахилгыг бэхжүүлэх арга хэмжээний тухай) гаргаж, байгууллагын санхүүгийн албанд Ерөнхий ба ахлах Нягтлан бодогчийн албан тушаалыг бий болгож дүрмийг баталсан. 1957 онд “Үйлдвэрийн газар, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн байдлын тухай”, СнЗ-ийн 424-р тогтоол

гарч, “Тайлан балансын дүрэм”, “Нягтлан бодох бүртгэлийн баримт ба түүний бичилтийн дүрэм”-ийг баталсанаар үйлдвэрийн газар, байгууллагын нягтлан бодох бүртгэлд тавигдах шаардлага өндөржин, Санхүү бүртгэлийн болон шалган байцаах мэргэжлийн боловсон хүчин, дээд боловсролтой нягтлан бодогч бэлтгэх зайлшгүй хэрэгцээ бий болсон байна.

Энэ шаардлагаар 1958 онд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо (УТТ)-ны 55-р тогтоол, СнЗ-ийн мөн оны 203-р тогтоолоор нягтлан бодогч нарын мэргэжлийг дээшлүүлэх болон СЭЗТ-ын дэргэд Нягтлан Бодох Бүртгэлийн дээд боловсролын оройн анги нээх болон МУИС-ийн Эдийн Засгийн Факультет (ЭЗФ)-ыг байгуулах шийдвэрүүд гарч, 1959 оноос Эдийн Засгийн Дээд Сургууль (ЭЗДС)-ийг тусгайлан байгуулж, 1960 оноос Нягтлан бодохын мэргэжлээр өдрийн ангийн элсэлт авсанаар тус тэнхим, мэргэжлийн түүх эхэлжээ.

2. Баланс судлал, шинжилгээний хичээлийг зааж ирсэн түүх

Шинэ Монгол улс өмнөх Богд хаант болон Манж чин улсын үеэс энгийн гар тэмдэглэлийн чанартай данс бүртгэлээс өөр Бүртгэлийн арга системийг өвлөн аваагүй бөгөөд 1924 оныг хүртэл улсын нийт санхүү, түүний орлого зарлагын тайлан тооцоог энэ л энгийн гар тэмдэглэлийн аргаар тэмдэглэж байжээ. Монгол улсын Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Гавъяат багш Ч.Түмэн (1988) өөрийн дурсамж номонд бичихдээ “Богд хаант засгийн Сангийн яамны архиваас судалж үзэхэд үнэндээ энгийн тэмдэглэлийн чанартай гар дансаар мөнгө, бараа, мал, эд юмсыг бараг нэг

дэвтэрт хамтатган мөнгөн үнэлэлтээр болон заримыг нь биет хэмжүүрээр хольж хутган бичиж, түүнийгээ данс гэж нэрлэн, сүрхий нандигнан хадгалж байснаас өөр бүртгэлийн ямар нэгэн систем байгаагүй нь илэрсэн юм” гэсэн байдаг.

Гавъяат багш, профессор Л.Дамбадорж (2003) “1921 оноос өмнөх үед манай улсад хэрэглэгдэж байсан тооцоо, бүртгэл нь гар тэмдэглэл, хөтөлгөө төдий хэлбэртэй байснаас биш, өнөөгийн бидний мэддэг давхар бичилтийн гайхамшигт аргыг огт хэрэглэдэггүй буюу мэддэггүй, тэр тухай сонсоо ч үгүй байсан болов уу” гэжээ. Ийнхүү бүртгэл тайлан бий болж, улс нийгмийн өмч хөрөнгийг элдэв зальхай аргаар идэж ашиглуулахгүйн тулд санхүүгийн хяналтыг сайжруулах, тайлан хүлээж авах журмыг боловсронгуй болгох, улсын орлого зарлагын нэгтгэл болон үйлдвэр, байгууллагын балансанд зөвлөлтийн сургагч нарын заавраар зэрэгцүүлсэн шинжилгээ хийж дүгнэлт бичүүлэх, түүнийгээ эрхэлсэн түшмэлүүд шүүн хэлэлцэх, дараа нь яам газрууд болон засгийн газарт өргөн барьдаг журам 1930-аад оноос эхэлж, улмаар тогтоосон хугацаагаар (улирал, жилээр) тайлагнах, Яам болон салбарын хэмжээнд санхүүгийн тайлангийн нэгтгэл хийж, балансын шинжилгээ, дүгнэлт тайлбар бэлтгэдэг тогтолцоо улс орны хөгжлийн явцаар 1940-1950-иад онд бүрэлдэн тогтжээ. Балансын шинжилгээ, “Баланс судлал” гэсэн нэрээр шинжилгээний хичээлийг 1935 онд Санхүүгийн техникум байгуулахад сургалтын төлөвлөгөөнд тусган зааж эхэлсэн байна. Санхүү, Эдийн Засгийн Дээд Сургууль (СЭЗДС)-ийн 90 жилийн ойд зориулан бүтээсэн “Өсөж өнөржин, өөдлөн дэлгэрсэн 90 жил” номонд орсон тус сургуулийн түүхийн

баримтуудаас үзвэл энэ хичээлийг “Балансын шинжилгээ” гэсэн нэрээр нийтдээ 120-128 цагаар (32 долоо хоногт тус бүр 4 цагаар) зааж ирсэн, 1944 онд Сангийн Яамны коллегоор хэлэлцэж баталсан 1944-1945 оны хичээлийн жилийн төлөвлөгөөнд хичээлийн нэр нь “Аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ” гэж өөрчлөгдсөн бөгөөд 1946-1951 оны урьдчилсан төлөвлөгөөнд тус хичээлийг 7 хоногт 10 цагаар (бүгд 320 цаг) заахад 2 багш шаардлагатай гэж төлөвлөж байсан бол 1952-1955 онд төсөв, үйлдвэр, банкны мэргэжлийн ангиудад аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ хичээлийг тус бүр 120-150-180 цагаар зааж ирсэн мэдээ байна. Энэ хичээлийг Монголд зааж байсан анхны багш нь 1935 онд Санхүүгийн техникумын сургагчаар ажиллаж байсан Фэльдман гэдэг ЗХУ-ын мэргэжилтэн байжээ. Монгол улсын нам төрийн зүтгэлтэн агсан Ю.Цэдэнбал гуайг 1938 онд ЗХУ-ын Эрхүүгийн Санхүүгийн сургуулийг төгсөж ирэхэд Монголын анхны дээд

боловсролтой эдийн засагч гэж онцлоод, 1938 оны намраас Санхүүгийн сургуулийн хичээлийн эрхлэгчээр томилон, зарим онц тусгай мэргэжлийн хичээлийг заалгахаар болж Балансын шинжилгээний хичээлийн ногдлыг хуваарилж байсан сонирхолтой баримт байна. Тэр үед тусгай мэргэжлийн хичээлийн орон тооны багш хүрэлцээгүй, зарим хичээлийг Сангийн яам, Монгол банкны ажилтнууд цагаар заадаг байсан. 1935 онд Ардыг гэгээрүүлэх яамнаас багш бэлтгэх сургууль (курс)-ийг ерөнхий эрдмийн ба тусгай мэргэжлийн гэсэн 2 бүлэгтэйгээр байгуулж Зөвлөлтийн сургагч багш нар, Монгол багш нарт өдрийн болон оройн цагаар Нягтлан бодох, Банкны ажил явуулга, Баланс судлал, Орлого зарлагын төсөв зохиолт гэхчилэн хичээлүүдийг зааж, тусгай мэргэжлийн багш нараа дадлагажуулан бэлтгэдэг байжээ. Тухайлбал: 1937-1938 оны хичээлийн жилийн эхэнд баталсан сургагч багш Фэльдманы тусгай мэргэжлийн багш нарт хичээл заах хуваарийг танилцуулвал:

Гараг	Заах хичээлийн нэр	Суралцах багш нар
Даваа	Санхүүгийн төлөвлөгөө	Түмэн, Тагар
Мягмар	Банкны ажил, явуулга	Осоржамаа, Цэвээн
Лхагва	Худалдааны тоо бодлого	Дугаржав, Тагар
Пүрэв	Баланс судлал	Түмэн, Пэрэнлэй
Баасан	Банкны нягтлан бодох	Осоржамаа, Цэвээн
Бямба	Баланс судлал	Түмэн, Пэрэнлэй

Ч.Түмэн багш маань тэр үед Нийтийн ба тусгай нягтлан бодох (одоогийнхоор бол Бүртгэлийн үндэс ба салбаруудын нягтлан юм болов уу)-ын хичээлийг зааж, түүнийхээ зэрэгцээгээр Баланс судлал, шинжилгээний хичээл заахаар суралцан бэлтгэгдэж байсан болон ахмад багш Л.Занабазарын хамт “Үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ” номыг 1957 онд бичиж хэвлүүлсэнээс үзвэл Нягтлан бодох бүртгэлийн зэрэгцээгээр

шинжилгээний хичээлээр мэргэшиж, энэ хичээлийг зааж ирсэний илэрхийлэл гэж болно. МУИС-д ЭЗФ байгуулсан 1958 оноос ялангуяа ЭЗДС байгуулагдсан үеэс Шинжилгээний хичээлийг тусгайлан зааж эхэлсэн болов уу. Шинжилгээний хичээлийг МУИС-д зааж эхэлсэн анхны багш нар нь Д.Баасанжав (1961), С.Цэвээнпүрэв (1963) нар, дараагийн (1970-аад оны) нь Б.Сайнжаргал (1972), Д.Балчинпүрэв (1974), Т.Жааваа (1975),

Л.Мөнх-Очир (1983), Д.Моломжамц (1990), Л.Наранчимэг (1991) гээд өнөөдрийн үед хүрч иржээ.

МУИС-д эхэн үедээ Шинжилгээний хичээлийг Аж үйлдвэрээс эхлээд УААА-н бүхий л салбаруудаар нь заадаг, энэ хичээлээр ангийн ажил бичиж, үйлдвэрлэлийн дадлага хийж, дипломын ажил бичдэг, төгсөлтийн улсын шалгалт өгдөг байсан юм. 1980-аад оны сургалтын төлөвлөгөөгөөр “ЭЗШ-ний онолын үндэс”-ээр шинжилгээний арга зүй, зохион байгуулалтын үндсийг нэг улирал үзээд, дараагийн улиралуудад Салбарын шинжилгээг нийтдээ 192-204 цаг буюу 2-3 улирал дараалуулан заадаг байжээ.

1990-ээд оноос дэлхийн улс орнуудын нийтлэг жишгийн дагуу Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд өөрчлөгдөн, Санхүүгийн бүртгэлээс гадна Зардалын бүртгэл, Удирдлагын бүртгэл, Аудит, Санхүүгийн менежмент, Маркетинг зах зээлийн судалгаа зэрэг олон хичээлүүд заагдах болсонтой холбоотойгоор Шинжилгээний хичээлийн хамрах хүрээ, агуулга хэмжээ эрс багасаж, хэсэг хугацаанд энэ хичээл Эдийн засгийн шинжилгээний онол, Аж ахуйн нэгж байгууллагын санхүү эдийн засгийн шинжилгээ гэсэн 2 хэсгээр заагдаж байснаа цаашдаа “Санхүү Эдийн Засгийн Шинжилгээ” гэсэн 3 багц цагийн заавал судлах нэг л хичээл болж, харин Хөрөнгө оруулалтын төслийн шинжилгээг сонгон суралцах хэлбэрээр заадаг болжээ. 1980-аад оноос Шинжилгээний хичээлийн танхимын дадлагын аргачлал, удирдамжийг боловсруулан 2-3 долоо хоног сургууль дээрээ багшийн удирдлагаар практик дадлага хийлгэдэг болсон нь оюутан суралцагчдад мэргэжлийн зохих дадлага чадвар эзэмшүүлэхэд чухал

түлхэц болсоныг тэмдэглэвэл зохино. МУИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн сургалтын шинэчилсэн төлөвлөгөө, хөтөлбөрүүд нь 1990-ээд оны үед мэргэжлийн бусад их, дээд сургууль (ИДС)-иуд үлгэр болон хэрэглэдэг байсан тул Шинжилгээний хичээлийг ч эдгээр сургуулиудад энэ жишгээр зааж ирсэн гэж болно.

Зөвлөлтийн болон Оросын холбооны улсын зохиогчдын тэмдэглэсэнээр Баланс судлал гэдэг нь зөвхөн балансын буюу одоогийн нэршилээр Санхүүгийн байдлын тайлангийн (хөрөнгө түүний санхүүжилтын бүтэц бүрэлдэхүүн, төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдлын) шинжилгээ дүгнэлтээс гадна өөрийн эргэлтийн хөрөнгө, ажлын капиталын хангамж ашиглалт, актив ба пассивын зохистой удирдлага, баланс тайлангийн зохиомж, үндсэн үзүүлэлтүүдийн харилцан хамаарал уялдаа холбоо, санхүүгийн тайлангийн хууль эрх зүйн болон бизнесийн гүйцэтгэлийн үндсэн ойлголтыг багтаасан, санхүүгийн тайланг хэрхэн уншиж ойлгох, мэдээлэл авахаас эхлээд тухайн байгууллагын үүрэг хариуцлага, бизнесийн үр дүнд үнэлгээ дүгнэлт өгөхөд чиглэгдсэн цогц судлагдахуун юм. Энэ утгаараа шинжилгээ нь баланс судлал, санхүүгийн тайланг хэрхэн унших арга зүйгээс эхэлж хөгжсөн, социалист аж ахуйн системийн үед аж ахуйн үйл ажиллагаа, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээнд илүүтэй ач холбогдол өгдөг байсан бол зах зээлийн эдийн засгийн өнөөгийн нөхцөлд Бизнесийн түгээмэл хэлээр зохиогдсон санхүүгийн тайлангийн шинжилгээ, санхүүгийн харьцаанууд санхүүгийн удирдлагын байр сууринаас шинжилгээнд хандах болсон байна. Манай улсын тухайд ч шинжилгээ нь энэ

л түүхэн замналаар цаг хугацааны хувьд арай хожуу давтагдан хэрэгжиж ирсэн гэж болно.

Өнөөдөр дэлхийн жишиг сургуулиудад санхүүгийн шинжилгээний хичээлийг нэг талаас санхүүгийн бүртгэл, гүйцэтгэлийн тайлагнал, зардал удирдлагын бүртгэл тооцоолол болон аудитын хичээлүүдээр, нөгөө талаас санхүүгийн болон бизнесийн удирдлага, бас хөрөнгө оруулалтын үр ашиг зэрэг хичээлүүдтэй холбон судалдаг бол ОХУ-д хуучин уламжлалаараа 300 гаруй цагийн хөтөлбөрөөр бие даасан судлагдахуун болгон зааж байна.

Санхүүгийн гүйцэтгэлийг нөлөөлсөн хүчин зүйлээр нь шинжлэн дүгнэлт өгөх, бизнес төлөвлөгөө, стратегийн бодлого, зорилгыг үндэслэлтэйгээр тодорхойлох удирдлагын арга хэрэгсэл болох шинжилгээний уламжлалт болон орчин үеийн арга зүй, зохион байгуулалтын онцлог, санхүүгийн харьцаануудын агуулгыг бизнесийн удирдлагын аль ч мэргэжлийн ажилтанууд сайтар танин мэдэж, шинжилгээний хүчин зүйлийн тооцоолол болон нэгдсэн үнэлгээ дүгнэлт өгөх дадлага, ур чадварыг эзэмшсэн байх шаардлагыг ажил олгогчийн зүгээс тавих боллоо. Энэ утгаараа санхүүгийн шинжилгээний хичээл цаашдаа ч бизнесийн удирдлагын ангиудад, тэр дундаа Нягтлан бодох бүртгэлийн мэргэжил эзэмших гэж буй бакалавр, магистрийн түвшний оюутан суралцагчдад санхүүгийн тайлагнал, бизнесийн гүйцэтгэлийн шинжилгээ, үнэлгээ дүгнэлт гэсэн агуулгаар заагдсаар л байх болов уу.

3. Суралцах материалын хангамж, шинэчлэл

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр бичигдсэн анхны томоохон бүтээл

(ном) бол Ч.Түмэн багшийн Зөвлөлтийн мэргэжилтэн сургагч А.А.Юрковтой хамтран зохиож, 1949 онд хэвлүүлсэн “Нягтлан бодох бүртгэлийн үндэс (онол)” сурах бичиг болов уу.

П.Савичев, И.Иванов нарын зохиосон “Үйлдвэрийн газрын баланс ба түүний шинжилгээ” гэдэг ном 1956 онд М.Лхамсүрэн, Д.Хожоо нарын орчуулгаар хэвлэгдсэн ба дараахан нь Ч.Түмэн, Л.Занабазар нарын “Үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ” (1957), Л.Лхамсүрэн, С.М.Мирошенко нарын “Аж үйлдвэрийн аж ахуйн санхүүгийн үйл ажиллагааны шинжилгээ, дүгнэлт” (1959) зэрэг номууд хэвлэгджээ.

1960-аад оноос ЭЗДС байгуулагдаж, оюутан суралцагчдын тоо өсөхийн хэрээр үндэсний сурах бичиг, суралцах материал, мэргэжлийн хялбаршуулсан ном товхимол, сургалтын гарын авлагууд. Аргачилсан заавар, журмууд шаардлагатай болсон нь мэдээж хэрэг.

Тэр үеэс “Эдийн засгийн судалгаанд хэрэглэгдэх тооны ухааны аргууд” (Л.Гүржав, 1965), “Үйлдвэрийн газрын бүтээгдэхүүний өөрийн өртөг, санхүүгийн байдлын шинжилгээ” (С.Лодой, С.Цэвээнпүрэв, 1968), “Аж үйлдвэр, барилгын байгууллагын аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ” (С.Цэвээнпүрэв, С.Лодой, Ч.Түмэн, 1971) гэх мэтээр үргэлжилсээр “Эдийн засгийн шинжилгээний бодлогын хураамж, аргачлал” (Б.Сайнжаргал, 1987) гээд дээд сургуулийн сурах бичиг, сургалтын гарын авлага, салбарын шинжилгээний аргачлал гэхчилэн 20 гаруй нэрийн ном хэвлэлүүд 1970-1980-аад онуудад хэвлэгдсэний бараг 80-90 хувь нь МУИС-ийн багш, эрдэмтдийн бичсэн бүтээлүүд байжээ.

Эдгээр он жилүүдэд үйлдвэрийн газар, байгууллагын шинжилгээний аргачлал батлагдаж, судалгааны нэгэн сэдэвт бүтээл, дээд сургуулийн сурах бичиг, сургалтын гарын авлага, бодлого, дасгалын хураамж хэдэн арваар хэвлэгдэж байсан нь тухайн цаг үеүдэд бүртгэл тайланг зөвхөн хуримтлуулан бүртгэж, тайлагнах агуулгаар төдийгүй, аливаа өмч хөрөнгө, зардлын хэмнэлтэнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, төлөвлөгөөт зорилтын биелэлт, нам засгийн бодлогын хэрэгжилтийг үнийн дүн төдийгүй, тоо болон чанарын үзүүлэлт, нөлөөлсөн хүчин зүйлээр нь судлан тодорхойлох, ашиглагдаагүй нөөц боломж, доголдол дутагдлыг илрүүлэн гаргахад шинжилгээний ач холбогдлыг тэргүүн зэрэгт авч үздэг байсантай холбоотой юм. Төвлөрсөн эдийн засгийн жилүүдэд аж ахуйн механизмыг боловсронгуй болгох, төлөвлөлт, эдийн засгийн урамшууллын шинэ системийг бүх салбаруудад туршин нэвтрүүлэх, арвилан хэмнэлт эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг улс орны хэмжээнд дэвшүүлж Санхүү-эдийн засгийн сургуулиудын сургалтын агуулга, судалгаа шинжилгээний ажил, бүхэлдээ энэ сэдэв рүү чиглэж байсны үр дүн гэж болно. 1990-ээд оноос нэг хэсэгтээ зах зээлийн орнуудын ИДС-иудад түгээмэл хэрэглэгддэг сурах бичгүүдийг, мөн ОУ-ын мэргэжлийн холбооноос батлан гаргасан НББ-ийн болон Аудитын стандарт, аргачлал журмуудыг орчуулан нийтийн хүртээл болгох, эдгээр тогтсон аргачлал хандлагыг танин мэдэж өөрийн болон нутагшуулан хэрэглэх бодлогыг баримталсан нь зөв зүйтэй алхам байлаа.

Энэ бодлогоор Санхүүгийн бүртгэл, Зардал-удирдлагын бүртгэлийн хэд хэдэн номуудыг хамтын орчуулгаар хэвлэж,

бас профессор Л.Дамбадорж Роберт Н.Энтоны “Нягтлан бодох бүртгэлийн үндэс” номыг 1988 онд, “Санхүүгийн тайланг хэрхэн судлах вэ?” номыг 1996 онд орчуулан хэвлүүлсэнээр Зах зээлийн үеийн Нягтлан бодох бүртгэлийн тогтсон арга зүйн талаар нэгдсэн ойлголт, мэдлэгтэй болоход чухал үүрэг гүйцэтгэжээ. 1990-ээд оноос өнөөг хүртэл Зардал-удирдлагын бүртгэл, шинжилгээний чиглэлээр мэргэшсэн эрдэмтэд болох Т.Жааваа, Н.Тунгалаг, С.Өлзийбат, Ц.Баянмөнх, Б.Баярмаа нарын номуудаас гадна шинжилгээний болон санхүүгийн менежментийн чиглэлээр Б.Сайнжаргал, Д.Моломжамц, Ц.Гунгаанямбуу, Л.Наранчимэг, Л.Жаргал, Ж.Бат-Өлзий нарын бичсэн хэдэн арван ном, сурах бичиг, суралцах материалууд хэвлэгдэж, ОХУ-ын болон барууны орнуудын сурах бичгүүдийг эх хэлээр нь уншин ашиглаж байна.

Эдгээрээс дүгнэвэл МУИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхим, багш нар баланс судлалаас эхлээд аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ, улмаар СЭЗШ-ний онол арга зүйг нутагшуулан хөгжүүлэх, төвлөрсөн төлөвлөгөөт болон зах зээлийн эдийн засгийн он жилүүдэд энэ хичээлийн хөтөлбөрийн агуулга хэмжээг зохистой тогтоох, сурах бичиг, сургалт арга зүйн материалын хангамжийг сайжруулахад дорвитой үүрэг гүйцэтгэж иржээ.

4. Мэргэжлийн судалгаа, боловсруулалтын ажил

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр Эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт судалгаа, эрдмийн зэрэг горилсон бүтээлүүд 1960-аад оны сүүл үеэс хийгдэж эхэлсэн. Тэр үед аспирантурын сургалтын систем, Эдийн засгийн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах мэргэшсэн Зөвлөлүүд

дотооддоо хараахан бүрэлдээгүй байсан учраас судлаачид голдуу ЗХУ-д аспирантурт суралцаж, диссертация тэнд очиж хамгаалдаг байжээ.

Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд ахмад эрдэмтэн агсан Р.Цагаанхүү 1967 онд, В.Нацагдорж 1968 онд, П.Жасрай 1970 онд тус бүрдээ ХАА, Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өөрийн өртгийн асуудлаар судалгаа хийж, өнөөгийн бидний ойлголтоор бол Зардал, удирдлагын бүртгэл, төлөвлөлт, хяналтын асуудлаар олон судлаачид эрдмийн зэрэг хамгаалсан нь Эдийн засгийн ухааны бүтээлд тооцогдож, чухамхүү Нягтлан бодох бүртгэлийн тухайлсан сэдвээр эрдмийн зэрэг горилохоос “тойрдог” байдал 1980-аад он хүртэл үргэлжилсэн нь Бүртгэлийн салбар ухааны ангилал, хөгжлийн түвшин, нарийн төвөгтэй байдал зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байсан болов уу. Нягтлан бодох бүртгэл, шинжилгээний сэдвээр хамгийн анх эрдмийн (дэд эрдэмтний) зэрэг хамгаалсан эрдэмтэн бол Тосонхандын Намжаа бөгөөд тэрээр МУИС-ийн ЭЗФ-ын деканаар ажиллахын зэрэгцээгээр горилогчийн хэлбэрээр суралцан 1972 онд “БНМАУ-ын хөнгөн аж үйлдвэрийн эргэлтийн хөрөнгийн шинжилгээ” сэдвээр ЗХУ-д, харин Банздайн Сайнжаргал 1980 онд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Эдийн засгийн хүрээлэнд “Хүнсний (чихэр боовны) үйлдвэрийн бүтээгдэхүүний өөрийн өртгийн бүртгэл, шинжилгээг боловсронгуй болгох асуудлууд” сэдвээр эрдмийн зэрэг хамгаалсанаар энэ мэргэжлээр эрдмийн зэрэг хамгаалах эхлэл болж, дараа дараагийн олон арван эрдэмтэн судлаачдыг араасаа дагуулсан юм. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр эрдмийн зэрэг хамгаалсан

болон хамгаалсан сэдэв нь арай өөр ч гэсэн эрхэлж ирсэн ажил алба, диссертаци хамгаалсаны дараах эрдэм шинжилгээний бүтээл туурвилаараа Монгол Улсад Нягтлан бодох бүртгэл, тайлагналыг хөгжүүлэх, бүртгэлийн шинэчлэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх болон мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд өөрийн хувь нэмрээ оруулсаар яваа эрдэмтдийн тоо 2017 оны байдлаар 60 шахам болж, тэдгээрээс Т.Жааваа 2003 онд, Д.Моломжамц 2007 онд, бүртгэлийн сэдвээр Шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалан мэргэжлийн судалгаа хөгжүүлэлтийг хошуучлан явна. Эдгээр эрдэмтдийн 60 гаруй хувь нь МУИС-ийн төгсөгчид болон багш нар байгаа нь бидний бахархал болж байдаг бөгөөд одоо ч тус тэнхимд энэ мэргэжлээр 10 гаруй докторант суралцаж байна. 1970-1990 оны хооронд хамгаалсан эрдэмтдийн олонхи нь манай орны уламжлалт салбар болох ХАА-н үйлдвэрлэлийн удирдлага, зохион байгуулалт, үр ашгийн болон мэргэжлийн салбарын хөгжлийн ерөнхий асуудлаар судалгаа хийдэг байсан бол өнөөгийн залуу эрдэмтэн судлаачдын цөөнгүй нь (Л.Болдбаатар, Б.Оюунцэцэг, Л.Энх-Амгалан нар) Бүртгэлийн мэргэжлийн боловсролын асуудлаар (Боловсрол судлал)-аар, бас цөөнгүй нь СТОУС-ыг өөрийн оронд нутагшуулах, Төрийн болон хараат бус аудитын тогтолцоо, Бүртгэл тайлагналын төлөвшил шинэчлэлт, түүний чанарын үнэлгээ, Хүмүүн капиталын бүртгэл, тайлагнал зэрэг орчин үеийн тулгамдсан сэдвүүдээр докторын зэрэг (Ph.D) горилсон судалгаа хийдэг болсон нь бас нэгэн дэвшил гэж болно.

Цаашдаа мэргэжлийн судалгаа хөгжүүлэлтийн тэргүүлэх чиглэл, тулгамдсан асуудлыг оновчтой

тогтоон, Монгол Улсад өнө эртнээс хэрэглэгдэж ирсэн Нягтлан бодох бүртгэлийн хэлбэрүүд, тэдгээрийн түүхэн сурвалжуудыг олж тогтоох, бас бизнесийн удирдлагын системийг төлөвшүүлэхэд бүртгэл-тайлагнал-шинжилгээ, аудитын гүйцэтгэх үүрэг, мэргэжлийн хөгжлийн дэлхий нийтийн чиг хандлага болон бүс нутгийн харьцуулсан судалгаа, мэргэжлийн онол арга зүйн орчин үеийн асуудалд төвлөрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Эцэст нь тэмдэглэхэд хараахандиссертаци бичиж, эрдмийн зэрэг хамгаалаагүй хэдий

ч хэдэн арван жил ИДС-иудад багшлан мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэсэн, мэргэжлийн онол арга зүйн асуудлыг судлан сурах бичиг, гарын авлага зэрэг олон арван бүтээл туурвисан, нэгэн цаг үед мэргэжлийн салбарыг удирдаж явсан, Монгол Улсын Гавьяат болон ардын багш Ч.Түмэн, Ж.Нямсүрэн, Л.Дамбадорж, доцент С.Лүндэн, ахлах багш С.Лодой, С.Цэвээнпүрэв, Д.Долгоржав, Ч.Дашням гээд энд нэр нь дурьдагдаагүй олон арван ахмадуудын бүтээлч хөдөлмөр, бүртгэл-шинжилгээний хөгжилд оруулсан жинтэй үүргийг дахин дахин дурсах учиртай.

Ашигласан материал

1. Түмэн, Ч. (1988). *Харанхуй манангаас гэгээн гэрэлд*, Улаанбаатар
2. Дамбадорж, Л. (2003). *Ахмад ба залуу үеийн зарим нягтлан бодогчдын дурсамж, бодрол*, Улаанбаатар
3. *Хос морьтон Чимэдийн Түмэн*, Улаанбаатар, 2010
4. *Монгол улсын санхүүгийн албаны түүх*, I ба II дэвтэр, Улаанбаатар, 1996
5. *Монгол Улсын Шинжлэх Ухааны цуврал ботиуд, Эдийн засгийн ухаан №34*, Улаанбаатар, 2010
6. МУИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхим (2008), *50 жилийн түүхэн замнал*, Улаанбаатар
7. *Өсөж өнөржин, өөдлөн дэлгэрсэн 90 жил (СЭЗДС-ийн 90 жилийн ойд зориулав)*, Улаанбаатар, 2014
8. *Эдийн засаг, бизнесийн удирдлагаар мэргэжилтэн бэлтгэсний 70 жил*, Улаанбаатар, 2017

